**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ/2020/01/-НА**

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга**
**бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
**Аудитын менежер А.Цээням**
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
**Ахлах аудитор Б.Должмаа**
Утас: 88119345 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn
**Аудитор П.Амаржаргал**
Утас: 88106992 цахим хуудас: amaraa_802002@yahoo.com
**Аудитор Ж.Өсөхбаяр**
Утас: 99890393 цахим хуудас: usukhbayar_j@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу

Баянхонгор хот 2020 он

*Тайланг бэлтгэсэн:*

*Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор*

*Б.Мөнхбат*

*Аудитын менежер*

*А.Цээням*

*Ахлах аудитор*

*Б.Должмаа*

*Аудитор*

*П.Амаржаргал*

*Ж.Өсөхбаяр*

*2020 оны 05 дугаар сарын 08*

*Тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Цахим хуудаснаас үзнэ үү:*

*www.audit.bayankhongor.mn*

*Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.*

*ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар*

## АГУУЛГА


ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ................................ 3
Хүснэгтийн товъёг ................................ 3
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН................................ 4
НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН ................................ 7
БҮЛЭГ 1. ................................ 7
1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн 79.3 хувь, 6.4-д заасан мэдээллийн 82.9 хувийг хугацаанд нь байршуулжээ. ...7
1.2. Шилэн дансны мэдээллээ байгууллагууд мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.......12
БҮЛЭГ 2. ................................ 12
2.1. Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллийг 13.6 хувийг мэдээлээгүй байна. 12
2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шатны талаарх мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй байна. 13
2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид ШДНЦХ-т бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.......13
БҮЛЭГ 3. ................................ 14
3.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тавих хяналт хангалтгүй байна. 14
3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.......15
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ.............. 17
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР ................................ 17
АУДИТЫН ДҮГНЭЛТ ................................ 18
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ................................ 19
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:................................ 20

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ҮАГ | - ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР |
| НАГ | - НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР |
| НА | - НИЙЦЛИЙН АУДИТ |
| УИХ | - УЛСЫН ИХ ХУРАЛ |
| ИТХ | - ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ |
| ЗДТГ | - ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР |
| СТСХ | - САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС |
| СХАА | - САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА |
| ОНХС | - ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН |
| ХАА | - ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА |
| ТЕЗ | - ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ |
| ТШЗ | - ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ |
| ИНХ | - ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ |
| ШДНЦХ | - ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС |

### Хүснэгтийн товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| *Хүснэгт 1* | *"ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээлэл* | *7* |
| *Хүснэгт 2* | *"ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийн төрөл тус бүрээр өмнөх онтой харьцуулснаар:* | *8* |
| *Хүснэгт 3* | *Тухайн мэдээлэл гарснаас хойш "ДОЛОО ХОНОГ"-ийн дотор байршуулах мэдээлэл.* | *9* |
| *Хүснэгт 4* | *Тухайн мэдээлэл гарснаас хойш "ДОЛОО ХОНОГ"-ийн дотор байршуулах мэдээллийг өмнөх онтой харьцуулсан судалгаа.* | *11* |


### Дүрслэлийн товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| *Дүрслэл 1* | *Хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын эзлэх хувь* | *7* |
| *Дүрслэл 2* | *Сумдын байршуулсан мэдээлэл* | *8* |
| *Дүрслэл 3* | *Хугацаа хоцроосон мэдээлэл* | *8* |
| *Дүрслэл 4* | *Хуулийн 6.4-д заасан мэдээллийн судалгаа* | *10* |
| *Дүрслэл 5* | *Шилэн дансны хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулсан судалгаа* | *12* |
| *Дүрслэл 6* | *Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагуудын судалгаа* | *14* |

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "ҮАГ-ын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-ний дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд нэгдсэн удирдамжаар хийж гүйцэтгэв.

## Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв.Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1[1], 3.1.2[2]-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3[3], 3.1.4[4],3.1.5[5]-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

## Аудитын хамарсан хүрээ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг түүвэрт хамруулж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

## Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн өмчит 33, орон нутгийн өмчит 179 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 2, төрийн өмчит үйлдвэрийн газар 2, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж буй 15 байгууллага, аж ахуйн нэгж, нийт 234 байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудас (цаашид ШДНЦХ гэх)-т мэдээлбэл зохих 24594 мэдээллээс 1031 мэдээллийг хугацаа хоцроож, 3385 мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах компаниуд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт,

---

[1] *"төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд"*
[2] *"төрийн өмчит үйлдвэрийн газар"*
[3] *"хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани"*
[4] *"улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага"*
[5] *"төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч"*

төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААН, байгууллагуудаас "Шанхай констракшн" ХХК-аас бусад ААН-үүд шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн асуудлын шинжилгээнээс 1 дүгээр зорилтын 3 дахь асуудал орон нутгийн түвшинд хамааралгүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээллийг байршуулах төлөвлөгөөг аймгийн СТСХ-ийн дарга 2017 оны 09 дүгээр сард шилэн дансны үндсэн 3-н цэсийг ажил үүргийн хуваарьтай нь уялдуулж төлөвлөгөө гаргаж, 2019 оны 10 дугаар сард тус төлөвлөгөөг шинэчлэн баталсны дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, Орон нутгийн өмчийн газрын холбогдох мэргэжилтнүүд хариуцан байршуулж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит 190 байгууллагыг хамруулан 2019 оны 1-4 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан ажилласан арга хэмжээ авч ажилласан байна.

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт, шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан "Нийцлийн аудитын түр журам"-ыг баримтлан хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгаж, дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулан аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд**

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- ✓ *Монгол Улсын Үндсэн хууль*
- ✓ *Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль*
- ✓ *Төрийн аудитын тухай хууль*
- ✓ *Шилэн дансны тухай хууль*
- ✓ *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль*
- ✓ *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль*
- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль*
- ✓ *Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"*
- ✓ *Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"*
- ✓ *Бусад холбогдох хууль, дүрэм, журам*

**Хүндрэл бэрхшээл**

Шилэн дансны мэдээллийг хянах эрхээр орж нэгтгэлийг авч үзэхэд "Хавсралт дээр тохиргоо хийгдээгүй байна. Нэгдсэн админд хандаж тохиргоо хийлгэнэ үү" гэж системээс мессеж өгч алдаа гарч байсан ба аудитын хавсралт судалгааны маягтыг бөглөхөд заавал тухайн байгууллага руу энгийн хандалтаар хандаж нарийвчлан үзэх шаардлага үүсэж байгаа нь цаг хугацаа ихээхэн шаардагдсан болно. Мөн Шилэн дансны цахим хуудсанд тавьсан мэдээллийг үзэхэд төвөгтэй, хэвлэж авах боломжгүй, байршуулсан мэдээллийн гүйлгээний тоог нийт дүнгээр татахгүй сарын тоогоор татдаг, тухайн цэсэд хэдэн хүн нэвтэрч мэдээлэл үзсэнийг харах боломжгүй байгааг цаашид анхаарч, системд шинэчлэлт хийж хөгжүүлэх шаардлагатай байна.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

**БҮЛЭГ 1.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтад хамаарах зарим байгууллагууд хуульд заасан мэдээллийг "Шилэн дансны нэгдсэн цахим хуудас"-т бүрэн байршуулаагүй

### 1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн 79.3 хувь, 6.4-д заасан мэдээллийн 82.9 хувийг хугацаанд нь байршуулжээ.

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтад хамаарах төрийн болон орон нутгийн өмчит **212** байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж **2**, төрийн өмчит үйлдвэрийн газар **2**, нийт **216** төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааг ил тод мэдээлэх цэс *Шилэн дансны нэгдсэн цахим хуудас /цаашид ШДНЦХ гэх/*-т нээгдэж, хуульд заасан мэдээллийг байршуулах боломжоор хангагдсан байна.

***Дүрслэл 1**. Хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын эзлэх хувь*




Аудитын дүнг гаргахдаа аудитын багаас Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд, босоо тогтолцоо бүхий байгууллагуудыг бүрэн хамруулан хуульд заасан мэдээллийг ШДНЦХ-т иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн эсэхийг холбогдох баримт материалтай тулган шалгаж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийн байдлыг тайланд хавсаргав. (Хавсралт №1, №2-д үзүүлэв)

Аудитаар хуулийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хамаарах мэдээлбэл зохих нийт 5999 мэдээллээс 79.3 хувь буюу 4756 мэдээллийг хугацаанд нь, 17.2 хувь буюу 1031 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, 3.5 хувь буюу 212 мэдээллийг байршуулаагүй байгаагаас жилийн эцсийн санхүүгийн тайланг 41 байгууллага, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 34 байгууллага байршуулаагүй байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна

**Хүснэгт 1.** "ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээлэл

| Шилэн дансны тухай хуулийн заалт | | Байгууллагын тоо | Тухайн мэдээлэл хамааралгүй | Мэдээлбэл зохих | Үнээс | | | Эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцорсон | Мэдээлээгүй | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцорсон | Мэдээлээгүй |
| 6.1.1 | Тухайн жилийн төсөв | 216 | 2 | 214 | 164 | 48 | 2 | 76.6% | 22.4% | 0.9% |
| | ОНХС-ийн төлөвлөгөө | 216 | 194 | 22 | 15 | 7 | 0 | 68.2% | 31.8% | 0.0% |
| | ХАА-ны төлөвлөгөө | 216 | 48 | 168 | 96 | 67 | 5 | 57.1% | 39.9% | 3.0% |
| 6.1.2 | Төсвийн гүйцэтгэл | 216 | 1 | 3661 | 3010 | 575 | 76 | 82.2% | 15.7% | 2.1% |
| 6.1.3 | Дараа жилийн төсвийн төсөл | 216 | 0 | 216 | 177 | 36 | 3 | 81.9% | 16.7% | 1.4% |
| 6.1.4 | Санхүүгийн тайлан /хагас жил/ | 216 | 1 | 215 | 180 | 32 | 3 | 83.7% | 14.9% | 1.4% |
| | Санхүүгийн тайлан /Жилийн эцсийн/ | 216 | 2 | 214 | 138 | 35 | 41 | 64.5% | 16.4% | 19.2% |
| 6.1.5 | ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт | 216 | 2 | 214 | 151 | 29 | 34 | 70.6% | 13.6% | 15.9% |
| | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч | 216 | 3 | 213 | 145 | 65 | 3 | 68.1% | 30.5% | 1.4% |
| 6.1.6 | Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | 216 | 1 | 862 | 680 | 137 | 45 | 78.9% | 15.9% | 5.2% |
| НИЙТ ДҮН | | | 254 | 5999 | 4756 | 1031 | 212 | 79.3% | 17.2% | 3.5% |

***Эх сурвалж:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудас*

***Аудитын илрүүлэлт:***

*-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсөв, ОНХС-ийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 7 байгууллага мэдээлээгүй;*

*- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл зохих 3661 мэдээллээс хугацаанд нь 3010, хугацаа хоцроож 575 мэдээллийг мэдээлсэн ба нийт 97.9 хувьтай байршуулсан байгаа нь өмнөх оны аудитын дүнгээс 0.1 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.*

*- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төсөл, 6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайлан, 6.1.5-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 40 байгууллага мэдээлээгүй;*

*- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-т заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг мэдээлбэл зохих 862 мэдээллээс хугацаанд нь 680, хугацаа хоцроож 137 мэдээллийг мэдээлсэн ба нийт 94.8 хувьтай байршуулсан байна.*

**Хүснэгт 2.** "ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийн төрөл тус бүрээр өмнөх онтой харьцуулснаар:

| Шилэн дансны тухай хуулийн заалт | | Хугацаандаа мэдээлсэн | | | Хугацаа хоцорсон | | | Мэдээлээгүй | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | Зөрүү | 2018 | 2019 | Зөрүү | 2018 | 2019 | Зөрүү |
| 6.1.1 | Тухайн жилийн төсөв | 82.2% | 76.6% | -5.6% | 13.5% | 22.4% | -9.0% | 4.3% | 1.0% | 3.3% |
| | ОНХС-ийн төлөвлөгөө | 90.5% | 68.2% | -22.3% | 9.5% | 31.8% | -22.3% | 0.0% | 0.0% | 0.0% |
| | ХАА-ны төлөвлөгөө | 87.1% | 57.1% | -30.0% | 9.1% | 39.9% | -30.7% | 3.8% | 3.0% | 0.8% |
| 6.1.2 | Төсвийн гүйцэтгэл | 89.9% | 82.2% | -7.7% | 9.1% | 15.7% | -6.6% | 1.0% | 2.1% | -1.1% |
| 6.1.3 | Дараа жилийн төсвийн төсөл | 70.6% | 81.9% | 11.3% | 0.5% | 16.7% | -16.2% | 28.9% | 1.4% | 27.5% |
| 6.1.4 | Санхүүгийн тайлан /хагас жил/ | 85.3% | 83.7% | -1.6% | 2.8% | 14.9% | -12.0% | 11.8% | 1.4% | 10.5% |
| | Санхүүгийн тайлан /Жилийн эцсийн/ | 93.3% | 64.5% | -28.8% | 0.5% | 16.4% | -15.9% | 6.2% | 19.2% | -12.9% |
| 6.1.5 | ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт | 90.0% | 70.6% | -19.4% | 0.5% | 13.6% | -13.1% | 9.6% | 15.9% | -6.3% |
| | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | 63.5% | 68.1% | 4.6% | 9.6% | 30.5% | -20.9% | 26.9% | 1.4% | 25.5% |
| 6.1.6 | Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | 86.8% | 78.9% | -7.9% | 3.4% | 15.9% | -12.5% | 9.8% | 5.2% | 4.6% |
| **НИЙТ ДҮН** | | **87.5%** | **79.3%** | **-8.2%** | **7.6%** | **17.2%** | **-9.6%** | **4.9%** | **3.5%** | **1.4%** |

***Эх сурвалж:*** *Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, өмнөх оны аудитын тайлан*

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хамаарах мэдээллийг сумаар авч үзвэл Өлзийт, Заг, Баянлиг сумдын төсөвт байгууллагууд байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан бол Жинст сумын төсөвт байгууллагууд 86.7%, Бөмбөгөр сумын төсөвт байгууллагууд 85.6%-ийг байршуулж хуулийг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс Баацагаан, Өлзийт, Заг сумд байршуулсан мэдээллийн дийлэнх хувийг хугацаанд байршуулсан бол Галуут сум мэдээллийн 44.4%, Шинэжинст сум 49.2%-ийг хугацаа хоцроож байршуулсан байна.

***Дүрслэл 2.*** *Сумдын байршуулсан мэдээлэл*




***Дүрслэл 3.*** *Хугацаа хоцроосон мэдээлэл*



Хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж мэдээллийг засварласан нь хугацаа хоцроосон төлөвтэй болж байгаа нь хугацаа хоцроосон мэдээлэл өндөр үзүүлэлтэй гарах шалтгаан болж байгаа гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтнууд өгч байгаа боловч үүнийг аудитаар нотлох боломжгүй байна.

Иймд цаашид хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанаас өмнө байршуулан, түүнд холбогдох албан тушаалтнууд хуулийн хугацаанд хяналт тавьж ажиллах зохицуулалтыг хийж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Аудитад хамрагдсан 216 байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт хамаарах мэдээлбэл зохих нийт 18597 мэдээллээс 82.9 хувь буюу 15422 мэдээллийг ШДНЦХ-т байршуулжээ.

***Хүснэгт 3.*** *Тухайн мэдээлэл гарснаас хойш "ДОЛОО ХОНОГ"-ийн дотор байршуулах мэдээлэл.*

| Шилэн дансны тухай хуулийн заалт | Хамааралгүй | Мэдээлбэл зохих | Үнээс | | Эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Мэдээлсэн | Мэдээлээгүй | Мэдээлсэн | Мэдээлээгүй |
| 6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | 0 | 216 | 154 | 62 | 71.3% | 28.7% |
| 6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | 203 | 13 | 13 | 0 | 100.0% | 0.0% |
| 6.4.3 Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл | 76 | 701 | 502 | 199 | 71.6% | 28.4% |
| 6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл | 26 | 6296 | 4813 | 1483 | 76.4% | 23.6% |
| 6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | 65 | 1918 | 1494 | 424 | 77.9% | 22.1% |
| 6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | 22 | 4678 | 4092 | 586 | 87.5% | 12.5% |
| 6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн | 119 | 97 | 30 | 67 | 30.9% | 69.1% |
| 6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | 24 | 192 | 188 | 4 | 97.9% | 2.1% |
| 6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл | 33 | 4484 | 4136 | 348 | 92.2% | 7.8% |
| **Нийт дүн** | 568 | 18595 | 15422 | 3173 | 82.9% | 17.1% |

***Эх сурвалж:*** *Шилэн дансны нэгдсэн цахим хуудас*

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь хэсэгт хамаарах мэдээллийн 2018 онд 96.2 хувийг мэдээлж байсан бол 2019 онд нийт мэдээллийн 82.9 хувийг мэдээлж өмнө оноос 13.3 хувиар буурсан ба бусад хяналт шалгалтын тайланг 67 байгууллага байршуулаагүйгээс Санхүүгийн хяналт аудитын албанаас 2019 онд хийсэн хяналт шалгалтын тайланг 56 байгууллага байршуулаагүй байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

***Хүснэгт 4.*** *Тухайн мэдээлэл гарснаас хойш "ДОЛОО ХОНОГ"-ийн дотор байршуулах мэдээллийг өмнөх онтой харьцуулсан судалгаа.*

| Шилэн дансны тухай хуулийн заалт | Мэдээлсэн | | | Мэдээлээгүй | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | Зөрүү | 2018 | 2019 | Зөрүү |
| 6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | 100% | 71.3% | -28.7% | 0.0% | 28.7% | 28.7% |
| 6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | 100% | 86.7% | -13.3% | 0.0% | 13.3% | 13.3% |
| 6.4.3 Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл | 100% | 71.6% | -28.4% | 0.0% | 28.4% | 28.4% |
| 6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл | 90.1% | 76.4% | -13.7% | 9.9% | 23.6% | 13.7% |
| 6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | 87.6% | 77.9% | -9.7% | 12.4% | 22.1% | 9.7% |
| 6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | 91.5% | 87.5% | -4.0% | 8.5% | 12.5% | 4.0% |
| 6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн | 100% | 30.9% | -69.1% | 0.0% | 69.1% | 69.1% |
| 6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | 100% | 97.9% | -2.1% | 0.0% | 2.1% | 2.1% |
| 6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл | 96.5% | 92.2% | -4.3% | 3.5% | 7.8% | 4.3% |
| **Нийт дүн** | 96.2% | 82.9% | -13.3% | 0.0% | 17.1% | 17.1% |

***Эх сурвалж:*** *Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, өмнөх оны аудитын тайлан*

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[6], 6.4.2[7], 6.4.3[8] дахь заалтын дагуу байршуулах мэдээллийг давхардсан тоогоор 235 байгууллагаас бусад байгууллагууд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

***Аудитын илрүүлэлт:***

***Шилэн дансны тухай хуулийн 6.4.4[9], заалттай холбоотой байршуулбал зохих 6271 гүйлгээнээс 1692 гүйлгээг 117 байгууллага, 6.4.5[10] дахь заалттай холбоотой 6640 гүйлгээнээс 1141 гүйлгээг давхардсан тоогоор нийт 118 байгууллага мэдээлээгүй, мөн хуулийн 6.4.8[11] -д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 4484 шийдвэрээс 353 шийдвэрийг 34 байгууллага мэдээлээгүй байна.***

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д хамаарах мэдээллийг сумаар авч үзвэл Баян-Овоо, Баянхонгор, Хүрээмарал, Гурванбулаг, Богд сумдын төсөвт байгууллагууд байршуулбал зохих мэдээллийг 90-ээс дээш хувьтай байршуулсан бол Бөмбөгөр, Баянцагаан, сумдын төсөвт байгууллагууд мэдээллийг 70-аас доош хувьтай байршуулж хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Дүрслэл 4.** Хуулийн 6.4-д заасан мэдээллийн судалгаа

| | Мэдээлбэл зохих | Үүнээс мэдээлсэн: Тоо | Хувь |
|---|---|---|---|
| Баян-Овоо | 377 | 359 | 95.2% |
| Баянхонгор | 3808 | 3583 | 94.1% |
| Хүрээмарал | 353 | 328 | 92.9% |
| Гурванбулаг | 561 | 506 | 90.2% |
| Богд | 335 | 302 | 90.1% |
| Өлзийт | 464 | 417 | 89.9% |
| Баацагаан | 469 | 405 | 86.4% |
| Жаргалант | 322 | 272 | 84.5% |
| Баян-Өндөр | 547 | 462 | 84.5% |
| Заг | 397 | 334 | 84.1% |
| Баянбулаг | 522 | 438 | 83.9% |
| Эрдэнэцогт | 428 | 356 | 83.2% |
| Бууцагаан | 678 | 553 | 81.6% |
| Жинст | 387 | 308 | 79.6% |
| Босоо бүтэцтэй байгууллага | 3758 | 2983 | 79.4% |
| Галуут | 494 | 390 | 78.9% |
| Баянлиг | 469 | 367 | 78.3% |
| Аймгийн ТЕЗ-ийн байгууллага | 2359 | 1831 | 77.6% |
| Шинэжинст | 377 | 289 | 76.7% |
| Баянговь | 467 | 347 | 74.3% |
| Баянцагаан | 380 | 245 | 64.5% |
| Бөмбөгөр | 645 | 347 | 53.8% |

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2[12], 8.4[13] дэх заалт, аймгийн ИТХ-ын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Тунгалаг санхүү" аймгийн хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/633 тоот захирамжаар "Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим хуудсанд мэдээлэл оруулах, хяналт хийх ажил"-ын төлөвлөгөөг батлуулсан.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/127 дугаар захирамжаар баталсан "Төсөвт байгууллагад төлбөр тооцооны гүйлгээ хийх, эрх олгох журам"-ын 2.2-т Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд гаргахыг 1, 2 дугаар гарын үсэг зурдаг албан

---

[6] *"тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт"*
[7] *"тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт"*
[8] *"тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан"*
[9] *"тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*
[10] *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"*
[11] *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"*
[12] *Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ."*
[13] *Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно*

тушаалтанд хариуцуулж, түүнд хяналт тавих үүргийг Санхүүгийн албаны дарга нарт даалгасан байхад 2019 онд сумд "Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө"-г сумын Засаг даргын захирамжаар батлахдаа зарим сумд Шилэн дансны хуульд заасан мэдээллийг хариуцах, хяналт тавих албан тушаалтныг томилж баталсан байхад зарим сумд батлаагүй ба хяналт тавих албан тушаалтныг зарим сум сумын Санхүүгийн албаны даргаар, зарим сумд төрийн сангийн мэргэжилтнээр томилсон байгаа нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Санхүүгийн албаны даргын албан тушаалын тодорхойлолт"-ын 2 дугаарын зорилтын 13-т заасан "Сумдын төсөвт байгууллагуудын шилэн дансны цахим хуудасны админ эрхийг эзэмшиж, байршуулсан мэдээллийг шалган улирал бүрэн тайланг илгээх" гэсэнтэй нийцэхгүй байна. Харин аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын баталсан хуваарийн дагуу төрийн сангаар гүйлгээ хийж байгаа 45 төсөвт байгууллагын Шилэн дансны хэрэгжилтэд төрийн сангийн 2 мэргэжилтэн хяналт тавьж байгаа боловч тус мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод байхгүй, тус үүрэг нь СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан байна.

Иймд сумдын Санхүүгийн албаны дарга, СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нарын ажлын байрны тодорхойлолтод дээрх чиг үүргийг оруулж, хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүй, алдаа зөрчлийг давтан гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нарт хүргүүлэв.

Төсөвт байгууллагуудын Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлд аймаг, сумдын Засаг даргын захирамжаар томилогдсон албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлэхдээ мэдээллийг анхан шатны баримттай тулган баталгаажуулдаггүй, мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан эсэхийг хянахгүй байгаагаас мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй зөрчил бүрэн арилахгүй, иргэд олон нийт баталгаажсан үнэн зөв мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрдэхгүйд хүргэж байна.

Тухайлбал Баянговь, Баянлиг, Баянхонгор, Бөмбөгөр, Богд, Бууцагаан, Галуут, Жаргалант, Жинст, Эрдэнэцогт сумдын зарим төсөвт байгууллагууд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг 70-аас бага хувьтай байршуулсан байгаа тул хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна. /Хүснэгт 5/

**Хүснэгт 5.** Хуульд заасан мэдээллийг ШДНЦХ-т байршуулсан хувь

| № | Байгууллагын нэр | Хуулийн 6.1 | Хуулийн 6.4 | НИЙТ |
|---|---|---|---|---|
| 1 | Баянговь сумын Соёлын төв | 96.3% | 37.5% | 66.9% |
| 2 | Баянговь сумын Засаг дарга | 79.3% | 27.8% | 53.5% |
| 3 | Баянлиг сумын бага сургууль | 100.0% | 37.7% | 68.9% |
| 4 | Баянхонгор сумын Засаг дарга | 100.0% | 38.3% | 69.2% |
| 5 | Богд сумын Засаг дарга | 100.0% | 33.3% | 66.7% |
| 6 | Бөмбөгөр сумын ЗДТГ | 67.9% | 18.5% | 43.2% |
| 7 | Бөмбөгөр сумын ИТХ | 85.2% | 35.3% | 60.2% |
| 8 | Бууцагаан сумын Засаг дарга | 96.6% | 31.1% | 63.8% |
| 9 | Галуут сумын Соёлын төв | 74.1% | 59.5% | 66.8% |
| 10 | Галуут сумын Засаг дарга | 82.8% | 22.9% | 52.8% |
| 11 | Жаргалант сумын ИТХ | 88.9% | 45.5% | 67.2% |
| 12 | Жинст сумын Засаг дарга | 48.3% | 28.9% | 38.6% |
| 13 | Эрдэнэцогт сумын Засаг дарга | 96.6% | 34.8% | 65.7% |

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд нийт мэдээлбэл зохих 24596 мэдээллээс 21209 мэдээлэл буюу 86.2 хувийг мэдээлсэн ба мэдээлэл байршуулсан байдлыг өмнөх онуудын аудитын дүнтэй харьцуулахад хуулийн 6.1 болон 6.4 дэх хамаарах байршуулбал зохих мэдээллийг байршуулсан хувь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй, байгууллагууд мэдээллийг хугацаандаа мэдээлсэн харагдаж байгаа хэдий ч мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг хангаагүй, мэдээллийг бүрэн оруулаагүй, хавсаргах баримтуудыг байршуулаагүй, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг дэлгэрэнгүй бичдэггүй зэрэг зөрчлүүд арилахгүй давтагдан гарсаар байна.

**Дүрслэл 5.** Шилэн дансны хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулсан судалгаа




Иймд ШДНЦХ-т байршуулж байгаа мэдээллийн чанар, үнэн зөв байдалд тавих шат шатны хяналтыг сайжруулж төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, ойлгомжтой мэдээлэх гэсэн хуулийн үндсэн зорилтыг хангаж, ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга нарт хүргүүлэв.

**1.2. Шилэн дансны мэдээллээ байгууллагууд мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.**

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д "Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна" гэж заажээ.

Аудитаар түүврийн аргыг ашиглан Баянхонгор аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 42 байгууллагын мэдээллийг шалгахад мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл нь төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, чөлөөтэй танилцах боломжоор хангасан хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалтыг хэрэгжүүлсэн байна.

**БҮЛЭГ 2.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд "Шилэн дансны нэгдсэн цахим хуудас"-т хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна

**2.1. Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллийг 13.6 хувийг мэдээлээгүй байна.**

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах 5 хуулийн этгээд өмнөх онд аудитад хамрагдаж байсан бол "Нью майнинг" ХХК-ийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 7/413 тоот албан бичгээр татан буулгах хүсэлт хүргүүлж, аймгийн ИТХ-ын 2020 оны 18 дугаар тогтоолоор татан буулгасан бол Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 07-ний А/02 тоот

захирамжаар "Шинэжинст тохижилт үйлчилгээний алба" төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсан нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдсан байна.

***Аудитын илрүүлэлт:***

*-"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК нь 4 тендер, худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй,*

*-"Чандмань Баянхонгор" ХК, нь 6 тендер, худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 3 шийдвэрийг байршуулаагүй,*

*-"Цэвэр хот" ОНӨХК нь төсөв, өмч хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг байршуулаагүй,*

*-"Шинэжинст тохижилт үйлчилгээний алба" нь 3 тендер, худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, төсөв, өмч хөрөнгө зарцуулах, төлбөртэй үйлчилгээний үнэ тариф тогтоосон 3 шийдвэрийг байршуулаагүй тул нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.*

### 2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шатны талаарх мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 [14] -т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9[15] дэх заалтад заасны дагуу гэрээний үндсэн дээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээг "Шанхай Констракшн групп" ХХК-аас бусад аж ахуйн нэгжүүд цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллийг байршуулаагүй байгаа нь нэг удаа тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж шилэн дансны цахим хуудсанд цэс үүсгэж дараа нь мэдээлэл байршуулах шаардлага гарахгүйгээс системд ашиглагдахгүй цэст байрших нь хуулийн холбогдох заалт хэрэгжих боломжгүйг харуулж байна.

Иймээс цаашид хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг энэхүү заалтын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягтаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

### 2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид ШДНЦХ-т бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5[16]-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа 14 аж ахуйн нэгж нь Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан

[14] *" 3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:...3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;"*

[15] *" Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй."*

[16] *"төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч."*

журмын 19 дүгээр хавсралтын дагуу улирал тутам мэдээллийг бүрэн байршуулсан байна.

